



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠢᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠤᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/178

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоол, 2021 оны 78 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 16 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн 7.6.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд бага насны буюу сургуулийн өмнөх боловсролын 2-5 настай хүүхдүүдийг гэр бүлийн орчинд нь эцэг эхийн дэргэд нь суралцах боломжийг хангах зорилгоор Хувилбарт сургалтын явуулын багшийн үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардагдах зардалд 19,000,000 (арван есөн сая) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О АМГАЛАНБААТАР